



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/90

Чингис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборын тохижилт, Батширээт сумын сургуулийн дотуур байрны барилга угсралт 100 ор, Спорт заалны тоног төхөөрөмж /Батноров, Дадал, Баянхутаг сум/ авах ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ц.Дэмбэрэлсайхан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	И.Баасанжав	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Даваасүрэн	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга / Ц.Дэмбэрэлсайхан /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010276